

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
ЭНГЭТМЭЭР УХЛААНЫ ФАКУЛЬТЕТ

# ТҮҮЖ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ № 488 (14) 2002 он

RUSSIA



INDIA

# Гарчиг

## Эрхэм уншигч Танаа

5

### Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

### Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

### Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

### Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

### Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

### Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

### Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

## Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал /XX зууны эхний хагас/

МУИС-ийн хүндэт проф, доктор/PhD/ Д.Хүүхэнбаатар  
Докторант П.Дэлгэржаргал /МУИС/

Монголын ноёдын үлэмж хэсэг нь Манжийн хүчирхэг төрийн дор нэгдэх нь Хятад, Оросын их гүрний эзлэн түрэмгийлэх болон "уусгах" бодлогоос хамгаалагдах найдвартай арга хэмээн үзэж байлаа. Ийм учраас Халхын ноёдууд Манжийн хаантай 1691 оны Долнуурын чуулганаар гэрээ байгуулан, Манжийн төрд дагаар орсон. Харин Манжууд Орос, Хятадаас Монголыг хамгаалах үүрэг авчээ. Энэ нь үндэсний урвалт биш, үндэсний хувь заяагаа аврах зөв сонголт байсан юм. Ийнхүү Монголчууд Манжийн төрийн найдвартай хамгаалалтан дор 200-аад жил амар амгалан оршин байв. Гэтэл XIX зууны II хагасаас Манжийн төрийн уламжлалт бодлого алдагдан өөрчлөгдсөөр, эцэстээ "Шинэ засгийн бодлого" гэгч Монголыг хятадчилах, шууд колоничлох бодлогод шилжжээ.

Чин гүрний онцгой статустай бүс нутаг байсны хувьд уламжлалт бодлогоо өөрчлөхгүй байхыг Монголын ноёдууд Манжийн хаан болон эрх баригчдаас удаа дараа шаардсан боловч түүнийг хүлээн авсангүй. Манжийн төрийн бодлого монголчуудыг Хятадын "уусгах" бодлогоос хамгаалах бус, харин Хятадын "уусгах" бодлогыг дэмжин хөхүүлэх болсон нь нийт монголчуудын дургүйцэл зэвүүцлийг хүргэжээ. Ийнхүү Манжийн төрөөс монголчуудад олгосон онцгой статус өөрчлөгдөн, манжийн төрийн бодлого улам бүр хятадчилагдан байгааг ухаарсан монголын дэвшилт үзэлтнүүд үндэсний нэгдэх хөдөлгөөнийг өрнүүлэн, төрийн тусгаар тогтнолоо олж авахын чухлыг улам бүр ухамсарлаж, хятадыг эсэргүүцэх хөдөлгөөн болж хувирсан байна.

Монголын үндэсний нэгдлийн үзэл санаа хөгжин төлөвшихөд дараах хүчин зүйлүүд нөлөөлсөн гэж үзэж болно.

1. Монголчуудын өөр хоорондын тэмцэл, тус тусдаа бие даах гэсэн эрмэлзэл, улс төрийн бутрал нь Монголын хүчийг сулруулан, харь гүрний эрхшээлд оруулахад хүргэсэн түүхээс сургаж авсан.

2. Монголыг Хятадын уусгах бодлогоос хамгаалж байсан Манжийн төрийн уламжлалт бодлого өөрчлөгдөн, Манжийн төрийн бодлого хятадчилагдсанаар монголчууд Хятадад уусах аюул шууд тулж ирсэн

3. XIX зууны сүүлчээс Монгол оронд гадаадын капитал ихээхэн нэвтэрч, монголчууд олон улсын хөгжлийн хандлагаас хэт хоцрогдсоноо улам бүр ухамсарлаж, хөгжин дэвжье, хүчирхэгжье гэвэл нэгдэн нийлж Нэгдсэн Монгол улс байгуулан, тусгаар тогтнолоо сэргээх зайлшгүй шаардлагатайг ухаарсан зэрэг болно.

XIX зууны сүүлч XX зууны эхэн гэхэд үндэсний нэгдлийн үзэл санаа хүчтэй дэлгэрч, нийт монголчуудыг хамарсан хүчирхэг хөдөлгөөн өрнөх урьдач нөхцөл бүрдсэн байна.

Аливаа юмс, үзэгдэл өөрийгөө хадгалах эрмэлзэл тэмүүлэлтэй байдаг бөгөөд угсаатан, үндэстэн ард түмний хувьд тусгаар тогтнолоо хамгаалах нь өөрийн мөн чанараа хадгалан хамгаалах арга зам байдаг. Иймд монголчуудын үндэсний нэгдэх хөдөлгөөн, тусгаар тогтнолын төлөө тэмцэл нь монголчууд өөрийн газар нутагтаа бүрэн эрхт эзэн байх, өөрийн соёл, зан заншил, шүтлэг бишрэл, язгуурын аж төрөх ёсоо хадгалан хамгаалахын төлөө, өөрөөр хэлбэл, монголчууд монголоороо үлдэхийн төлөө, өөрөө өөртөө эзэн байж эрх чөлөөгөө олж авахын төлөө тэмцэл байлаа.

1900-гаад оноос эхлэн Ар болон Өвөр Монголын олон газар нутагт орон нутгийн чанартай тэмцэл хөдөлгөөн өрнөж эхэлжээ. Өвөр Монголд Баяр, Тогтох тайж, Б.Хайсан гүн, Сумьяа бэйсийн тэмцэл, Өлзийжаргалын удирдсан дугуйлангийн хөдөлгөөн, Халхад Улиастайн 2000 цэргийн бослого, дугуйлангийн хөдөлгөөнүүд, 1905, 1907 оны Их хүрээний лам, ардуудын бослого, Хятадын худалдаачдыг эсэргүүцсэн орон нутгийн ардуудын болон сайн эрсийн тэмцэл гэх мэт бослого тэмцэл, хөдөлгөөнүүд газар сайгүй гарах болов. Монголд Шинэ засгийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ гүнзгийрэх тутам Монголчуудын үндэсний нэгдэх хөдөлгөөний эрч хүч далайц нэмэгдэж байлаа.

ХХ зууны сүүлчээс эхлэн ХХ зууны эхнээс хүчтэй өрнөсөн үндэсний нэгдэх хөдөлгөөн нь нийт монголчуудыг хамарсан өргөн далайцтай хөдөлгөөн байсан төдийгүй үүнд монгол туургатны анги давхрагынхан идэвхитэй оролцож байв. Үндэсний нэгдэх хөдөлгөөний явцад тус тусдаа бие даан тусгаарлах гэсэн үзэл болон ястан, угсаатны бүлгийн явцуу сонирхлыг даван туулж, монголчууд нэгдэхийн, нэгдсэн Монгол улс байгуулахын чухлыг ойлгон ухаарч, үзэл санааны нэгдэл тогтсон нь том амжилт байлаа. Тэмцлийн торгон үзүүр нь Хятадын колоничлол, "уусгах" бодлогын эсрэг чиглэж байсан бөгөөд энэ бодлогыг хэрэгжүүлэх улс төрийн хэрэгсэл болж байсан Манжийн ноёрхол, Манжийн төрийн эсрэг давхар чиглэж байв.

Орон нутгийн чанартай байсан тэмцэл хөдөлгөөний зорилго, шинж чанар улам бүр өргөжин, заргын болон эдийн засгийн шинжтэй, орон нутгийн чанартай тэмцлээс улс төрийн шинжтэй нийт үндэсний чанартай хөдөлгөөн болон өрнөжээ.

1911 оны үндэсний хувьсгал нь монголчуудын эрх чөлөө, тусгаар тогтнол, үндэсний нэгдэх хөдөлгөөний дээд оргил байлаа. Монголчууд газар сайгүй бослого тэмцэл өрнүүлж байсан ч ХХ зууны эхэн үе гэхэд Халхын дэвшилт эх орончдын үзэл санааны нэгдэл, тэдний ухаалаг бодлого, тэмцлийн арга зам, Халхчуудын газар зүйн байршил зэрэг нь нийт монголчуудын улс төрийн тэмцлийн төв болоход нөлөөлөв. Үүнд Оросын геополитикийн бодлого дэвшилт үүрэг гүйцэтгэсэнийг тэмдэглэх хэрэгтэй. Монгол угсаатны дотор тусгаар тогтнол, нийгмийн дэвшлийн төлөө хөдөлгөөнийг санаачлан манлайлагч нь ямагт Халхчууд байж, тэгээд ч бусад монголчууд нь Халхаа тойрон нэгдэн нягтарч, эе эвээ нэгтгэн тусгаар тогтнолоо хамгаалан сэргэн мандах Монгол үндэсний үзэл баримтлал ч нэгэнт бүрэлдэн тогтсон байна. Ийнхүү нийт Монгол угсаатныг нэгтгэх, төвлөрүүлэх үүргийг Халх нь гүйцэтгэн, тэдний итгэл найдвар, монголчуудын нэгдэх хөдөлгөөний төв болов. Иймд Барга, Өвөр Монгол, Буриадаас дэвшилт үзэлтэй олон хүмүүс Халхад ирж, нэгдэх хөдөлгөөнд идэвхитэй оролцон, нэгдсэн Монгол улс байгуулахын төлөө хүчин зүтгэсэн билээ. Нийт Монгол угсаатан, нийгмийн бүх анги давхрага, хүчний эе эвийг эрхэмлэн нэгтгэхэд шашныг үзэл суртлынхаа үндэс болгожээ. Шашны их нэр хүндээр төрөө төвшитгэх бодлогыг тэр үеийн улс төрийн зүтгэлтнүүд боловсруулж, баримтлан хэрэгжүүлсэн байна. Үндэсний нэгдэх хөдөлгөөн, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд шашин, түүний сэхээрэлт тэргүүний лам нар дэвшилт үүрэг гүйцэтгэсэн байна. Тусгаар тогтнол, Үндэсний нэгдэх хөдөлгөөнд Богд Жабзундамба хутагт идэвхитэй оролцож, түүний асар их нэр хүнд нь монгол угсаатны үндэсний нэгдлийн билэгдэл, илэрхийлэл болж байлаа.

1911 онд Халхад өрнөсөн үндэсний хувьсгал нь Ойрад, Барга, Өвөр Монгол зэрэг нийт монголчуудын нэгдэх хөдөлгөөнд хүчирхэг түлхэц өгч, тусгаар тогтнол, үндэсний нэгдэх хөдөлгөөнийг хүчтэй өрнүүлэв. 1912 онд баруун Монголыг чөлөөлөн, Ойрадууд нэгдэн орсоноор Ар Монголын нийт нутаг

дэвсгэрийг Богдын засгийн газар хяналтандаа авч чаджээ. Өвөр Монголын 49 хошуунаас 35 нь шинэ Монгол улсад дагаар орохоо илэрхийлэн төлөөлөгчдөө Нийслэл хүрээн дэх Богдын засгийн газарт ирүүлжээ. Хятадын цэргийг эх нутгаасаа хөөн гаргаж, нэгдсэн Монгол улс байгуулах тэмцэл Өвөр Монгол даяар өрнөв./12, т. 89-93/

Монголын засгийн газар үндэс угсаа нэгт Өвөр Монголын ах дүү нараа хамгаалан чөлөөлөх шийдвэр гаргаж, Богд хааны зарлигаар 1913 оны 1-р сарын 25-нд таван замын их цэргийг Өвөр Монголд илгээжээ.

Энэхүү цэргийг мордохоос өмнө Монголын Засгийн Газраас Өвөр Монгол, Барга, Ил, Алаштаа, Хөх нуурын монголчуудад хандан гаргасан ухуулах бичигт "Бидний язгуураас нэгэн угсааны яс махны төрөл дотоод, гадаад хэмээн ялгаваас зохихгүй. Та нар иргэнд (хятадтай) ойр суусан тул тэдний сүр хүчинд, аюулд хүлцэн бүхүйг манай Засгийн хэрэг шийтгэх Газар мэднэ... Бидний монгол бүгдээр нийлж нэгэн улс болж язгуураас байсан газар орон зах хэлхээг эзлэн илүү хүй газрыг тэмцэхгүй болбоос Дундад Улсын дайлах цэрэг гарваас олон гадаад улсад шударгыг барьж шүүмжлэх буй за." Та нар монгол цэрэгт тусалж "... шаламгайлан газар орноо эзлэн авсугай. Бид язгуураас нэгэн үндэсний тул зүй нь жаргавч, зововч, төрөвч, үхэвч хамт болбаас зохино"/16, т. 41-42/ хэмээн эх нутгаан Хятадын дарангуй цэргээс чөлөөлөн, нэгдсэн Монгол улс байгуулахыг уриалсан байдаг. Монголын цэрэг ялалт байгуулж, Өвөр Монголын нэлээд нутгийг чөлөөлжээ. Гэвч Орос, Хятадын шахалтаар 1913 оны сүүлч 1914 оны эхээр арга буюу Өвөр Монгол дахь байлдааны ажиллагаагаа зогсоон, таван замын цэргээ татаж, хиагтын гурван улсын хэлэлцээнд төлөөлөгчөө илгээх болжээ. 1911-1914 оныг хүртэл үргэлжилсэн нийт Монгол нутгийг хамарсан нэгдсэн Монгол улс байгуулахын төлөөх зэвсэгт тэмцэл нь үндэсний нэгдэх хөдөлгөөний оргил байлаа. Ийнхүү Монголын засгийн газар арга буюу зэвсэгт тэмцлийн замаасаа татгалзан дипломатын аргаар нийт монголчуудыг нэгтгэн нэгдсэн МОНГОЛ улс байгуулахын төлөө тэмцлээ үргэлжлүүлжээ.

Харамсалтай нь Орос Хятад хоёр 1913 оны Бээжингийн тунхаглалаар тохирсон тохиролцоогоо Хиагтын гэрээгээр Монголд тулган хүлээлгэж, зөвхөн Ар Монголыг Хятадын автономи болгосон нь Монголын тусгаар тогтнолыг төдийгүй ялангуяа монголчуудын нэгдэх хөдөлгөөнд томоохон цохилт болжээ. Хиагтын гэрээгээр Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлж чадаагүй ч цаашид тусгаар тогтнолоо олж авах эхлэлийг тавьсанаараа ихээхэн ач холбогдолтой хэмээн ихэнх судалаачид үздэг. Гэвч Хиагтын гэрээний хамгийн гол сөрөг нөлөө нь монголчуудын үндэсний нэгдэх хөдөлгөөнд хагарал гаргаж, Монгол нутгийг хоёр том хөршийн нөлөөний хүрээнд хуваах олон улсын эрх зүйн үндсийг тавьсан явдал юм. Хиагтын гэрээгээр Оросууд Ар Монголд эдийн засгийн хувьд ноёрхох эрхтэй болсноор цаашид Оросын нөлөөний бүс болсон билээ. Хиагтын гэрээгээр Ар Монгол тусгаар тогтнолоо бүрэн олж чадаагүй ч нэлээн өргөн эрхтэй автономи болж Өвөр Монгол, Хятадын жирийн нэгэн муж болов. Тийм учраас Хиагтын гэрээг тууштай эсэргүүцэн, Өвөр Монголын тусгаар тогтнол, нэгдсэн Монголын төлөө тууштай тэмцсэн Харчин гүн шударга баатар Бавуужав нарын зэрэг эх орончид олон бий. Том гүрнүүдийн нөлөөний хүрээгээ хуваах улс төрийн бодлого нь Монголчуудын үндэсний нэгдэх хөдөлгөөнийг ийнхүү таслан цохижээ. Хэдийгээр монгол үндэсний нэгдэх тэмцэл энэ удаа амжилт олж чадаагүй ч Монголын эх орончид тэмцлээ үргэлжлүүлсээр байсан юм.

Энэхүү хатуу ширүүн тэмцлийн явцад VIII богд Жавзундамба, Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, Сайн ноён хан Намнансүрэн, Хичээнгүй гүн Гомбо-Идшин, Хайсан гүн, Тогтох тайж, Манлай баатар Дамдинсүрэн, Сумьяа бэйс, Харчин гүн Бавуужав нарын зэрэг Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний

удирдагчид төрөн гарсан бөгөөд тэдний үзэл санаа, залгамж халааг С.Данзан, Жамсрангийн Цэвээн, Ширнэндамдин, А.Амар, Э.Ренчино, Х.Чойбалсан нарын зэрэг зүтгэлтнүүд залган авч тэмцлээ үргэлжлүүлжээ.

Бүс нутгийн улс төрийн байдал тогтворгүй байсан 1920-иод онд том гүрнүүд Нармай Монголын үзэл буюу Монголын нэгдэх хөдөлгөөнийг өөрийн зорилгодоо ашиглахыг хичээж байв.Тухайлбал, 1918 оноос Японы цэргийнхэн Семеновоор дамжуулан Нармай Монголын хөдөлгөөнийг дэмжин зүүн хойд Хятад болон Монголд өөрийн нөлөөгөө дэлгэрүүлэх зорилгодоо ашиглахыг оролджээ.Өвөр Монгол, Барга, Буриадын төлөөлөгчид Нармай Монголыг байгуулах асуудлыг хэлэлцэн, Нэйс гэгээнээр толгойлуулсан Түр засгийн газрыг байгуулан, Парисын бага хуралд төлөөлөгчөө илгээхээр шийдэж , өөрийн армия зохион байгуулахаар болжээ. Энэхүү Нармай Монголын засгийн газар байгуулсныг Колчакын засгийн газар "Хиагтын гурван улсын гэрээ"-г зөрчлөө хэмээн эрс эсэргүүцэн, Англи, АНУ-д мэдэгдсэн бөгөөд тэд ч эсэргүүцлээ илэрхийлэн Японыг Нармай Монголын засгийн газрыг дэмжлээ хэмээн буруутгасан байна. Нармай Монголын засгийн газар байгуулах хуралд Ар Монголын төлөөлөгчид очоогүй болон Англи, АНУ-ын хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан, Японы засгийн газрын бодлогод өөрчлөлт орж, Колчакын засгийн газрыг дэмжих болсон зэрэг шалтгааны улмаас энэ засгийн газрын үйл ажиллагаа төдийлэн амжилт олсонгүй./ 6, т. 36-37/

Удалгүй 1919 оны намар Хятадын цэрэг Ар Монголд орж, автономитыг устгав. Ар Монголд тусгаар тогтнолын төлөө тэмцэл өрнөж, үндэсний ардчилсан хувьсгал ЗОУ-ын тусламжтайгаар яллаа. Большевикууд Коминтернээр дамжуулан большевизмыг дэлгэрүүлэх бодлогодоо Нармай Монголын үзэл, Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөнийг ашиглахыг оролджээ. Энэ зорилгодоо ихэвчлэн Буриадын Нармай Монгол үзэлтнүүдийг ашиглан, тэднээр дамжуулан Ар Монгол болон Өвөр Монголд большевизмыг дэлгэрүүлэн өөрийн нөлөөгөө тэлэхийг зорьж байв.

Ийнхүү гадны хүчнүүд Монголын нэгдэх хөдөлгөөн, Нармай Монголын үзлийг өөрийн зорилгодоо ашиглахыг зорьж байхад Монголын нэгдэх хөдөлгөөний гол зүтгэлтнүүд Орос Хятад хоёр хөрш болон дэлхийн бусад улсуудаар хүлээн зөвшөөрөгдсөн нэгдсэн Монгол улс байгуулахыг зорин тэмцэж байлаа.

МАН-ын анхны мөрийн хөтөлбөрт: Монгол овогтныг алсдаа нэгэн холбоонд нэгтгэж улс төрөө байгуулах тухай зааж, үндэсний нэгдлийн асуудлаар тууштай зарчим баримталж байлаа.

"Тагна Тувааг Монголд эргүүлэн нэгтгэх " асуудлыг ЗОУ-тай хэлэлцээ хийх үед СДанзан шургуу тавьж байсан бөгөөд бид монгол үндэстнийг нэгтгэн нэгэн их улсын үзэл саналтай хэмээн монголыг нэгтгэх асуудлыг дэвшүүлж байжээ. Тэрээр 1922 оны эхээр нийслэлийн намын үүрүүдийн төлөөлөгчдийн хуралд "Монгол үндэстнийг нэгтгэж, улсын суурийг бататгах тухай" илтгэлийг тавьж хэлэлцүүлжээ./10, т. 22/ Монголын нэгдэх хөдөлгөөний зүтгэлтнүүд Туваг Монголд нэгтгэх, Оросын харъяат буриадуудыг монголд чөлөөтэй ирж суурьших нөхцлийг бүрдүүлэх асуудлыг Оросын тал удаа дараа тавьсны үр дүнд тохиролцоонд хүрч олон мянган буриадууд Монголд ирж суурьшжээ.

Ардын засгийн газраас өвөр Монголын нөлөө бүхий хүмүүстэй холбоо тогтоон, Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөнийг дэмжих бодлогыг баримталж байв. Тухайлбал, Ц.Ширнэндамдинг Өвөр Монголд 1923,1924,1927 онуудад удаа дараа томилон явуулж, тэндхийн нөлөө бүхий хүмүүс болох Бандид гэгээн , Найман ван, Харчин гүн Гүнсэнноров, Наянт ван, Баргын Мэрсээ, Фумин зэрэг хүмүүстэй уулзан холбоотой байсан төдийгүй, С.Буяннэмэх, Ц.Дамбадорж нар

удаа дараа очиж, Өвөр Монголын улс төрийн хүчнүүдтэй холбоотой байж үндэсний нэгдэх хөдөлгөөнийг цаашид үргэлжлүүлэн гүнзгийрүүлэх бодлогыг явуулж байжээ.

Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөн, нармай Монголын үзлийг онолын түвшинд цэгцтэй боловсруулсан хүн бол Ж.Цэвээн юм. Тэрээр Гадаад Монгол, Барга, Өвөр Монгол, Буриадыг нэгтгэсэн Төв Азийн холбооны улс байгуулах үзэл санааг дэвшүүлж, "СССР, Хятад хоёроос баталсан бөгөөд бусад олон улсаас хүлээн зөвшөөрсөн төвийг сахих улс болох хэрэгтэй. Энэ нь үлгэрлэвээс Швейцери улс лугаа адил буй..." / 23. 45/ гэж бичиж байсан.

Харамсалтай нь 1928 оноос засгийн эрхэнд гарсан зүүнтнүүдийн бодлого болон 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн уршгаар Нармай Монголын үзэл, Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний гол зүтгэлтнүүдийг хэлмэгдүүлэн устгажээ.

Гэвч нармай Монголын үзэл санаа тасран устаагүй бөгөөд 1945 онд Гадаад Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх асуудал тавигдахад Монголын Засгийн газар Өвөр Монголыг чөлөөлөн өөртөө нэгтгэх, дагаар орох хүсэлтэй элэг нэгтэй Монголчуудаа монголд ирэхийг дэмжих бодлого явуулжээ. Үүний дунд Хөлөн буйрын хошуу ноён Шаарийбуу албат харъяатаа дагуулан Монголд орж ирсэн төдийгүй, өмнө дүрвэсэн болон дагаар орох хүсэлтэй олон монголчууд өөрийн голомт нутаг руугаа орж ирсэн билээ.

XX зууны II хагасаас эх оронч болон нармай Монголын үзэл санаатай хүмүүсийг үндсэрхэг үзэлтэн нэрээр нухчин дарах хяхах хавчих бодлогыг МАХН, төр засгаас өрнүүлэх болсон юм.

Хэдийгээр 1990-ээд оноос үндэсний нэгдлийн болон нармай Монголын үзэл санаа чөлөөтэй хөгжих нөхцөл бүрдсэн ч нармай Монголын үзэл санаа нь урьдын уламжлалаасаа хэт тасарсан төдийгүй, түүний түүхийг судлан шинжилж төрийн бодлогын хэмжээнд боловсруулан хэрэгжүүлэх асуудал одоо хир хийгдээгүй байна.

Ном зүй

1. Амар.А. Монголын товч түүх.УБ.,
- 2.БНМАУ-ын түүх.Дэд боть.УБ., 1968
- 3.БНМАУ-ын түүх. УБ.,1984
- 4.Бадрах.Ө. Намаас баруун бөөрөнхийчүүдтэй тэмцсэн амжилттай их тэмцлийн туршлага.УБ.,2001
- 5.Базаров.Б.В.,Цибиков.Б.Д., Очиров.С.Б., ред. кол. Элбег-Доржи Ринчино Монголии.Улан-Удэ.,1998.
6. Батбаяр.Ц. Монгол ба Япон ХХ зууны эхэн хагаст.УБ.,1998
7. Болдбаатар.Ж. Амар сайд. Булган хот.,1993
8. Болдбаатар.Ж. Эрдэнэ дайчин чин ван Ханддорж. УБ.,1994
1. Болдбаатар.Ж. Да лам. УБ., 1997.
2. Даш.Д. Солийн Данзан.УБ.,1990
11. Дэндэв. Л. Монголын товч түүх.УБ., 1934
- 12.Жамсран. Л. Монголчуудын сэргэн мэдлэн эхэн.УБ., 1992
- 13.Жүгдэр.Ч. XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр философийн сэтгэлгээний хөгжил.УБ.,1972
- 14.Коминтерн ба Монгол.УБ.,1995
- 15.Лхамсүрэн.Б.Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол.УБ.,1995
- 16.Магсаржав.Н. Монголын шинэ түүх.УБ.,1994
- 17.Майский. И.М. Монголия накануне революции.М.,1959
- 18.Пунцагноров.Ц. Монголын автономитын үеийн түүх.УБ.,1955
- 19.Сандаг.Ш.Монголын улс төрийн гадаад харилцаа.1 дэвтэр.УБ.,1971
- 20.Урангуа.Ж. ХХ зууны үеийн Ар Монгол дахь шинэтгэл. УБ., 1997 он.
- 21.Чойбалсан.Х. Лосол. Г.Дэмид. Монгол ардын үндэсний хувьсгал анх үүсч байгуулагдсан товч түүх.УБ.,1979.
- 22.Ширэндэв.Б. Монгол ардын хувьсгалын түүх. УБ., 1969 он.
- 23.Шинжлэх ухаан амьдрал.1990.№4